



## ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Эрх олгох тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ын 8.3, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 6.2, 9.1-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Атомын Энергийн Агентлаг хооронд “Техникийн хамтын ажиллагааны хүрээ 2022-2027” баримт бичгийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

2. Монгол Улс болон Олон Улсын Атомын Энергийн Агентлаг хооронд байгуулах “Техникийн хамтын ажиллагааны хүрээ 2022-2027” баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжавт олгосугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД  
КОМИССЫН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН